



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 09 сарын 16-ны
өдрийн 4467 дугаарт бүртгэв.

2019 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

**Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг
баталгаажуулах журам батлах тухай**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 27 тоот тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”; 13 дугаар хавсралтаар баталсан “Баталгаажуулалтад хамруулах мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн ангилал хамрах хүрээ, мөрдөх стандартын жагсаалт”-ыг тус тус хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн
29 тоот тогтоолын хавсралт

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАГВАРЫГ БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

Монгол улсын Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ нь Монгол улсын Харилцаа холбоо, өргөн нэвтрүүлэг болон мэдээлэлийн технологийн салбарыг зохицуулах мэргэжлийн чиг үүрэг бүхий 2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Харилцаа холбооны тухай Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан байгууллага юм.

Зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 20.3, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.3-д заасны дагуу Монгол улсын зах зээлд нэвтэрсэн болон нийлүүлэгдэх харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулж тохирлын гэрчилгээ олгоно.

Тус баримт бичгийг бүтээгдэхүүний баталгаажуулалтын чиглэлээр Олон улсын стандартчиллын байгууллага, Олон улсын Цахилгаан техникийн комисс болон загварын туршилтын талаар Олон улсын хууль эрхийн хэмжил зүйн байгууллагаас боловсруулсан стандарт, арга зүйн удирдамжуудад нийцүүлэн боловсруулсан.

Энэхүү журмаар мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж /цаашид “бүтээгдэхүүн буюу тоног төхөөрөмж” гэх/-ийн баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах ерөнхий харилцааг тогтооно.

Энэ журмын хамрах хүрээнд дараах 2 төрлийн баталгаажуулалтын үйл ажиллагаа зохицуулагдана. Үүнд:

- Заавал баталгаажуулалт
- Сайн дурын баталгаажуулалт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан радио ба харилцаа холбооны тоног төхөөрөмжүүд нь заавал баталгаажуулалтад хамрагдана (Хавсралт 11). Тус жагсаалтад хамрагдаагүй үйлдвэрлэлийн болон гэр ахуйн зориулалттай цахилгаан тоног төхөөрөмжүүдийг сайн дурын баталгаажуулалтад хамруулж болно.

Хоёр. Зорилго

2.1 Тухайн бүтээгдэхүүн нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын талаар холбогдох норматив техникийн баримт бичигт тогтоосон шаардлагыг бүрэн хангасныг үнэн зөв нотлох;

2.2 Хэрэглэгчид зөв сонголт хийх боломж олгох, зах зээлд хуурамч болон стандарт шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүн орж ирхээс хамгаалах;

2.3 Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн холбогдох заалтууд /13, 14-р зүйл/, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол /Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт/-ын хэрэгжилтийг хангах, “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, баталгаажсан

бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгох, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

Гурав. Норматив ишлэл

3.1 Энэхүү баримт бичгийг боловсруулахад дараах баримт бичгүүдийг ашигласан. Эдгээр баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Радио долгионы тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол;
- MNS ISO/IEC 17065 Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага;
- MNS ISO/IEC 17067 Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар;
- MNS ISO/IEC 17000 Тохирлын үнэлгээ - Тайлбар толь, ерөнхий зарчим;
- MNS ISO/IEC TR 17026 Тохирлын үнэлгээ – Биет бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн загвар;
- MNS OIML D 19:2007, Загварын туршилт ба баталгаа.

Дөрөв. Баталгаажуулах үйл ажиллагаа

Бүтээгдэхүүнийг баталгаажуулах, тохирлын гэрчилгээ олгох үйл явцыг энэхүү журмын хавсралт 1, бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийг хавсралт 2, заавал баталгаажуулах бүтээгдэхүүний жагсаалт болон дагаж мөрдөх стандартын жагсаалтыг хавсралт 11-д тус тус үзүүлэв.

Тав. Хүсэлт гаргах

5.1 Тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, импортоор нийлүүлэгч, Монгол Улс дах албан ёсны гэрээт борлуулагч эсвэл төлөөлөгч болох Монгол Улсад бүртгэлтэй иргэн эсвэл хуулийн этгээд /цаашид “хүсэлт гаргагч” гэх/ нь тухайн тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах хүсэлтээ энэхүү журмын Хавсралт 3, Хавсралт 4-д заасан өргөдлийн дагуу гаргаж дараах материалыг Монгол эсвэл англи хэл дээр бүрдүүлэн Зохицуулах хороонд цахимаар болон цаасаар ирүүлнэ. Үүнд:

- Хүсэлт гаргасан албан бичиг;
- Үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн итгэмжлэл;
- Үйлдвэрлэгч/нийлүүлэгчийн тохирлын мэдэгдэл;
- Хүсэлт гаргахаас өмнө 6 жилийн дотор хийгдсэн Европын холбооны стандартын (EN) сорилтын дүн. Үүнд:
 - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (Health & Safety)
 - Цахилгаан соронзон зохицоо (Electromagnetic compatibility)
 - Радио давтамжийн спектийн үр ашигтай хэрэглээ (Effective use of radio frequency spectrum for radio communications equipment);

- Ашиглалтын товч танилцуулга, тохиргоо хийх заавар;
- Зураг (гадна болон дотоод бүтэц);
- Хэрэглэгчийн гарын авлага /Англи эсвэл Монгол хэл дээр/;
- Төхөөрөмж тус бүрт Зохицуулах хорооны гэрээний төслийг гарын үсэг, тамгаар баталгаажуулсан 2 хувь. Хавсралт 7;
- Үнэн зөв бөглөсөн гэрчилгээний загвар. Хавсралт 8;
- Шаардлагатай тохиолдолд өргөдөл гаргагчаас бүтээгдэхүүний загвар, блок схем, ажиллагааны зарчмын схем, гэх мэт нэмэлт мэдээлэл гаргуулж болно.

5.2 Дээрх материалууд бүрдээгүй тохиолдолд тохирлын үнэлгээ хийхээс татгалзана.

5.3 Хүсэлт гаргагч нь нэгээс олон төхөөрөмжинд тохирлын гэрчилгээ гаргуулах хүсэлтэй бол өргөдлийн маягтыг төхөөрөмж тус бүрт гаргана.

5.4 Хэрэв тухайн төхөөрөмж нь өмнө нь Зохицуулах хорооноос тохирлын гэрчилгээ авсан бөгөөд тохирлын гэрчилгээ нь хүчинтэй бол дахин тохирлын гэрчилгээ олгохгүй.

Зургаа. Тохирлын үнэлгээ

6.1 Тохирлын үнэлгээг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх авсан баталгаажуулалтын мэргэжилтэн хийнэ. Баталгаажуулалтын мэргэжилтэн тохирлын үнэлгээний удирдамж боловсруулж батлуулна. Шаардлагатай тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг байгуулж болно.

6.2 Ирүүлсэн материал, бүтээгдэхүүний онцлог, тавигдах техникийн шаардлагуудыг харгалзан баталгаажуулалтын үндсэн схемүүдээс дараах 2 чиглэлээр схем сонгоно. Үүнд:

- Баримт бичигт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;
- Баримт бичигт үнэлгээ хийхийн зэрэгцээ ирүүлсэн загварт сорилт хийх аргыг хослуулах;

6.3 Монгол Улсын стандарт, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт, Зохицуулах хорооноос баталсан радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага болон бусад холбогдох олон улсын стандарт, баримт бичгийг хангаж байгаа эсэхийг хянаж шалгана.

6.4 Радио долгион хяналтын төвийн баталгаажуулалтын үйл ажиллагаанд ашиглаж буй хэмжүүрийн багажууд нь шалгалт тохируулга хийгдэж баталгаажсан эсвэл нийлүүлэгч талын гаргасан баталгаат хугацаа нь хүчинтэй, сорьж турших ажил гүйцэтгэхэд батлагдсан стандарт аргын заавартай байна.

6.5 Өмнө нь туршилтад орж байгаагүй шинэ, дэвшилтэт технологиор үйлдвэрлэсэн тоног төхөөрөмжийн загварын сорилт туршилтыг Зохицуулах хорооны хүрээнд явуулах техникийн болон хүний нөөцийн хувьд боломжгүй нөхцөлд ижил статус бүхий Засгийн газрын бусад байгууллага, бие даасан сорилт, туршилтын байгууллага эсвэл их дээд сургуулийн лаборатори, гадны улс орны төрөлжсөн эрх бүхий лаборатори, үйлдвэрлэгчийн тоног төхөөрөмж, мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчинг ашиглан явуулж болно. Энэ тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах сорилтын дүнгийн хуудаст лабораторийн болон баталгаажуулалтын байгууллагын эрх бүхий мэргэжилтнүүд тус тус гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

6.6 Баталгаажуулалтын шинжээч эсвэл үнэлгээний ажлын хэсэг нь баримт бичгийн үнэлгээ, болон сорилт туршилтын дүнг хамтатган санал дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд дараах зүйлс тусгагдсан байна. Үүнд:

- Туршилтын нэгдсэн дүн;
- Бүтээгдэхүүний тодорхойлолт;
- Бүтээгдэхүүнийг баталгаажуулах, эсвэл туршилтанд тэнцээгүй бол энэ тухай нэмэлт үндэслэл;
- Бүтээгдэхүүнийг ашиглах хүрээ;
- Суурилуулалт, хамгаалалт, магадлах болон давтан үнэлгээтэй холбогдсон шаардлага;
- Санал болгож буй бүтээгдэхүүний баталгааны хүчинтэй хугацаа;

Долоо. Шийдвэр гаргах

7.1 Баталгаажуулалтын шинжээч эсвэл үнэлгээний ажлын хэсэг нь бүтээгдэхүүнд хийсэн тохирлын үнэлгээний үр дүн, тайланг Баталгаажуулалтын зөвлөлийн хуралд танилцуулж, тохирлын гэрчилгээ олгох, сунгах, татгалзах тухай шийдвэрийг гаргуулна.

7.2 Баталгаажуулалтын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн Зохицуулах хорооны даргын батламжилсан гэрчилгээ олгоно.

7.3 Баталгаажуулалтын зөвлөл нь сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногийн Пүрэв гаригт хуралдана.

7.4 Баталгаажуулалтын зөвлөлийн хуралдааныг цахимаар явуулж гарын үсгээр баталгаажуулж болно.

Найм. Тохирлын гэрчилгээ олгох, бүртгэх

8.1 Баталгаажуулалтын шинжээч нь бүтээгдэхүүний “Тохирлын гэрчилгээ”-нд бүртгэлийн дугаар олгож, бүртгэнэ.

8.2 Гэрчилгээнд баталгаажуулалт явуулахад үндэслэсэн баримт бичгүүдийг Хавсралт 8-ын дагуу тусгана.

8.3 Хүсэлт гаргагчийн хүсэлтийн дагуу тохирлын гэрчилгээнд бичигдэх хүсэлт гаргагчид үйлдвэрлэгч, нийлүүлэгч эсвэл худалдан борлуулагчийн нэрийг бичиж болно.

8.4 Нэг ижил төрлийн төхөөрөмжүүд (загварын дугаарууд нь өөр боловч лабораторийн сорилт, үйлдвэрлэгчийн мэдэгдэл нь ижил), модул болон эцсийн бүтээгдэхүүнийг баталгаажуулалтад хамруулна.

8.5 Хэрэв нэг ижил төрлийн төхөөрөмжүүдийг нэг гэрчилгээн дээр бичих бол зөвхөн 4 хүртэлх загварын нэр бичигдэнэ.

8.6 Бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний үр дүн сөрөг гарсан тохиолдолд баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээ олгохоос татгалзсан тухай шийдвэрийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

8.7 Гэрчилгээний хүчинтэй хугацааг тухайн бүтээгдэхүүний зохион бүтээлт боловсруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний тогтвортой байдал, норматив техникийн баримт бичгийн хүчинтэй хугацаа зэргийг харгалзан 3 хүртэлх жилийн хугацаагаар тогтооно.

8.8 Бүтээгдэхүүний зохион бүтээлт эсвэл үйлдвэрлэлийн технологи болон норматив техникийн баримт бичгийн шаардлагад тохирох байдалд нөлөөлөхүйц өөрчлөлтийг хийвэл хүсэлт гаргагч нь энэ тухай Зохицуулах хороонд урьдчилан мэдээлнэ. Үүний дагуу Зохицуулах хороо нь уг бүтээгдэхүүний сорилтыг шинээр явуулах үйлдвэрлэлийг нь дахин үнэлэх талаар шийдвэр гаргана.

8.9 Тохирлын гэрчилгээний хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор шийдвэрлэж, хүсэлт гаргагчид үр дүнг мэдэгдэнэ.

8.10 Хүсэлт гаргагч нь гэрчилгээний төлбөрийг төлбөрийн нэхэмжлэлийн дагуу Зохицуулах хорооны дансанд шилжүүлж ресепшинд төлбөрийн баримтын хуулбарыг өгч тохирлын гэрчилгээг баталаажсан гэрээний хамт авна.

Ес. Магадлах хяналт

9.1 Монгол Улсын зах зээлд нэвтэрсэн бүтээгдэхүүнд магадлах хяналтыг явуулна.

9.2 Бүтээгдэхүүний үзүүлж болох болзошгүй хохирлын зэрэг, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, хэмжээ, ISO 9001 менежментийн тогтолцоотой эсэх зэргийг шалгуур болгож магадлах хяналтын давтамж ба хамрах хүрээг тогтооно.

9.3 Тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээнд магадлан хяналтыг явуулахаар заасан бол гэрээнд заасан нөхцлийн дагуу магадлах хяналт явуулна.

9.4 Магадлах хяналт нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд:

- баталгаажуулсан бүтээгдэхүүний талаар ирж байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- хяналт явуулах ажлын хэсэг байгуулах;
- бүтээгдэхүүнийг сорилт туршилтанд хамруулж түүний үр дүнд дүн шинжилгээ хийх;
- хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн дунд санал асуулга явуулах;
- хяналтын дүнг нэгтгэн шийдвэр гаргах;

9.5 Магадлах хяналтын үр дүнг баримтжуулна. Баримтжуулсан мэдээллийн эх хувийг Зохицуулах хороонд хадгална. Хувийг хүсэлт гаргагчид болон магадлах хяналтад оролцсон байгууллагуудад хүргүүлнэ.

9.6 Магадлан хяналт явуулахаас өмнө тухайн хуулийн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

9.7 Магадлах хяналтын бүртгэлийг баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн бүртгэнэ. Магадлах хяналтын үр дүнгийн дагуу дараах тохиолдолд гэрчилгээг түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгоно. Үүнд:

- Холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэхгүй байх;
- Хэрэглэгчийг төөрөгдүүлсэн тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх;
- Аюулгүйн тэмдгийг буруу хэрэглэх;
- Бүтээгдэхүүний бүтээц, бүрдэлд өөрчлөлт орох;
- Үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн горимд өөрчлөлт орох;

9.8 Хүсэлт гаргагч нь Зохицуулах хороотой зөвшилцөж, тогтоосон хугацаанд залруулах арга хэмжээ авч илэрсэн үл тохирлыг арилгаж, стандартын шаардлагад тохирсныг баталж чадах тохиолдолд дахин шинжилгээ хийлгүйгээр түдгэлзүүлэх шийдвэрийг хүчингүй болгоно.

9.9 Залруулсан арга хэмжээ нь шаардлагад нийцэхгүй тохиолдолд гэрчилгээ нь хүчингүй хэвээр үлдэнэ. Гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсвэл хүчингүй болгосон тухай шийдвэрийг хүсэлт гаргагч, хэрэглэгчид, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, болон бусад сонирхогч талуудад мэдээлнэ.

Арав. Гэрчилгээ сунгах

10.1 Тохирлын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгах хүсэлтээ гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60 ба түүнээс дээш хоногийн өмнө энэ журмын 5.1-д заасны дагуу Зохицуулах хороонд гаргана.

10.2 Давтан үнэлгээг анхдагч үнэлгээ явуулахтай ижил зарчмаар хийнэ. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэхийг хянаж биелүүлсэн тохиолдолд тохирлын гэрчилгээний хугацааг хүчинтэй хугацаанаас хойш 3 хүртэлх жилээр сунгаж, нэгдсэн бүртгэлд тэмдэглэж эзэмшигчид нь буцааж олгоно.

10.3 Тохирлын гэрчилгээнд сунгалт хийхдээ тоног төхөөрөмжийн загвар, бүтцэд өөрчлөлт ороогүй тохиолдолд сорилт туршилтын хугацааг харгалзахгүй байж болно.

10.4 Бүрдүүлж ирүүлсэн баримт бичигт үндэслэн шинээр олгох гэрчилгээнд холбогдох өөрчлөлтүүдийг оруулж болно.

Арван нэг. Гэрчилгээг хүчингүй болгох

11.1 Баталгаажуулалтын зөвлөл нь баталгаажуулалтын байгууллагаас явуулсан магадлах хяналтын дүн, холбогдох мэргэжилтэн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, шаардлага, хэрэглэгч, сонирхогч бусад талуудаас ирүүлсэн гомдлыг үндэслэн тохирлын гэрчилгээг хүчингүй болгох тухай шийдвэр гаргана.

11.2 Тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон боловч хугацааг сунгуулаагүй нөхцөлд энэхүү гэрчилгээ нь хүчин төгөлдөр бус болно.

11.3 Тохирлын гэрчилгээ олгох болон сунгах баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэр гарсан хэдий ч гэрчилгээний төлбөрийг төлөөгүй тохиолдолд уг тохирлын гэрчилгээг хүчингүйд тооцно.

Арван хоёр. Сайн дурын баталгаажуулалт

12.1 Тус баримт бичгийн хавсралт 11-д тодорхойлогдсон заавал баталгаажуулалтанд хамрагдах радио ба цахилгаан холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжүүдээс бусад төрлийн цахилгаан тоног төхөөрөмжүүдийг хүсэлтийн дагуу баталгаажуулалтанд хамруулж болно.

12.2 Сайн дурын баталгаажуулалтанд бүтээгдэхүүний тохирлыг холбогдох норматив баримт бичгүүдээр тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг үнэлж тогтооно. Сайн дурын баталгаажуулалтыг заавал баталгаажуулалтанд хамрагдах бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн дагуу явуулна. Тохирлын үнэлгээнд хамрагдаж шаардлага хангасан тохиолдолд тохирлын гэрчилгээ олгоно.

Арван гурав. Баталгаажсан тоног төхөөрөмжид тохирлын тэмдэг олгох

13.1 Зохицуулах хорооны тохирлын тэмдгийн загвар, ашиглах заавар, зөвлөмжийг Зохицуулах хорооноос боловсруулан баталж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Оюуны өмчийн газар, Стандартчилал, хэмжилзүйн газарт бүртгүүлнэ.

13.2 Зохицуулах хорооны тохирлын тэмдэг нь дотоодод үйлдвэрлэсэн эсвэл экспортлох радио ба харилцаа холбооны тоног төхөөрөмжүүдэд заавал тавигдах ба импортын төхөөрөмжүүдэд заавал тавигдах шаардлагагүй байна.

Арван дөрөв. Олон нийтэд мэдээлэх

14.1 Баталгаажуулалтын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нь тухай бүр шинэ, нэмэлт, өөрчлөлт орсон баталгаажуулалтын баримт бичгүүдийг Зохицуулах хорооны цахим хуудаст байршуулна.

14.2 Баталгаажуулалтад хамрагдаж тохирлын гэрчилгээ олгогдсон төхөөрөмжүүдийн жагсаалтыг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү баримт бичгийн хавсралт 10-ын дагуу хавсралт 11-д тодорхойлсон төхөөрөмжүүдийн төрлөөр ангилан Зохицуулах хорооны цахим хуудсанд оруулан нийтэлнэ.


Арван тав. Хяналт


Энэхүү баримт бичгийн хэрэгжилт болон баталгаажуулалтын үйл ажиллагаанд Зохицуулах хорооны дотоод аудит, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч болон Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллага нь хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.


----- оОо -----

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
1 дүгээр хавсралт

Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг
баталгаажуулах үйл ажиллагаа







“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
2 дугаар хавсралт

**Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг
баталгаажуулах схем**

№	Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа	Баталгаажуулалтын схемийн төрлүүд								Эрхзүй, стандарт, техникийн баримт бичиг
		1a	1б	2	3	4	5	6	7	
1	Баталгаажуулалтын өргөдөл хүлээн авч, иж бүрдэл шалгах	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”
2	Баталгаажуулалтын өргөдөлд хавсаргасан баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”
3	Баталгаажуулалтын схем сонгох, үнэлгээний удирдамж боловсруулах, батлуулах	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам” “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийх төлбөрийн хэмжээ”
4	Загварын дээж авах, сорилт туршилтанд хамруулах	✓	✓	✓	✓	✓	✓	✓	-	“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”
5	Техникийн баримт бичиг, сорилтын тайланд дүн шинжилгээ хийж тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам” “Баталгаажуулалтад хамруулах харилцаа холбооны тоног төхөөрөмжийн ангилал хамрах хүрээ, мөрдөх стандарт, БТКУС”
6	Тохирлын гэрчилгээ олгох, сунгах танилцуулга, дүгнэлт боловсруулж Баталгаажуулалтын үнэлгээний хороогоор хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	“Тохирлын үнэлгээний тайлан, танилцуулга бичих заавар”
7	Тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулах, тохирлын гэрчилгээ, тохирлын тэмдэг олгох	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”

										“Баталгаажуулалтын гэрчилгээ олгох, хадгалах, хугацаа сунгах, цуцлах журам” “Мэдээлэл, харилцаа холбооны баталгаажсан тоног төхөөрөмжид тохирлын тэмдэг олгох журам”, “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид тохирлын тэмдэг хэрэглэх заавар”
8	Багц бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгох	-	✓	-	-	-	-	-	-	MNS ISO/IEC 17067:2014 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар стандарт” “Баталгаажуулалтын гэрчилгээ олгох, хадгалах, хугацаа сунгах, цуцлах журам”
9	Зах зээл дээрээс дээж авч сорилт буюу хяналт хийх	-	-	✓	-	✓	✓	-	-	MNS ISO/IEC 17067:2014 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар стандарт”
10	Үйлдвэрээс дээж авч сорилт буюу хяналт хийх	-	-	-	✓	✓	✓	-	-	MNS ISO/IEC 17067:2014 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар стандарт”
✓ Эдгээр схемүүдээр тоног төхөөрөмжийн загварын сорилт хэмжилтийн дүн болон дагалдах баримт бичигт хийсэн дүн шинжилгээ хийж гэрчилгээ олгоно.										
✓ Тухайн ажилтан сонгосон схемийн дагуу заагдсан ажлуудыг заавал хийнэ.										

Баталгаажуулалтын схемийг ашиглах тайлбар, Үүнд:

- 1а схем- импортын тоног төхөөрөмжийн загварын дээжийг авч баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана. Баталгаажуулалтын зөвлөлийн шийдвэрээр тохирлын гэрчилгээг **хоёр** хүртэл жилийн хугацаатай олгосон, сунгасан бүтээгдэхүүнд магадлан хяналт хийхгүй. Харин тохирлын гэрчилгээг нь 3 жилийн хугацаатай олгосон, сунгасан бүтээгдэхүүнд магадлан хяналтыг хоёр жилд нэг удаа явуулна.
- 1б схем- импортын тоног төхөөрөмжийн бүтэн багцыг баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
- 2 дугаар схем- дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, бүтээгдэхүүний загвар дээжийг авч магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
- 3 дугаар схем- зах зээлээс тодорхой хугацааны давтамжтайгаар импортын болон дотоодын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн загвар дээжийг авч, магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.

- 4 дүгээр схемийг үйлдвэрлэл болон зах зээлээс дээрээс тодорхой хугацааны давтамжтайгаар дотоодын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дээжийг авч магадлан хянаж баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана.
- 5 дугаар схем- магадлан хяналт шаардлагагүй, тоног төхөөрөмжийн загварын дээж шаардлагагүй, техникийн үзүүлэлт, сорилт туршилтын үр дүнг Монгол Улсад харилцан хүлээн зөвшөөрөх талаар хоёр талт болон бүс нутаг, олон улсын хэлэлцээрт гарын үсэг зурсан гадаад орны ижил төрлийн байгууллагаас олгосон загварын туршилтын гэрчилгээ, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүнтэй импортын тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглана

----- оОо -----

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
3 дугаар хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ӨРГӨДӨЛ

1. Хүсэлт гаргагчийн эрх бүхий болох тухай мэдээлэл

Монгол улсад бүртгэлтэй иргэн эсвэл хуулийн этгээд мөн эсэх Тийм Үгүй

Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөр төлсөн эсэх Тийм Үгүй

Сүүлийн 3 жилийн хугацаанд мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон эсэх Тийм Үгүй

Сүүлийн 3 жилийн авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсоныг хуульд заасны дагуу шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон эсэх Тийм Үгүй

Төлбөрийн чадвартай эсэх Тийм Үгүй

Бүтээгдэхүүний дээж ирүүлсэн эсэх Тийм Үгүй

Энэхүү маягтын дагуу миний/бидний өгсөн мэдээлэл, дагалдах баримт бичгүүд үнэн зөв болно; Харилцаа холбооны зохицуулах хорооны заасан дүрэм журам, бодлого, зохицуулалт, стандартыг би (бид) мөрдөнө;

Харилцаа холбооны зохицуулах хороог өргөдөлд хавсаргасан баримт бичгийн талаар сорилтын лаборатори, үйлдвэрлэгч, баталгаажуулалтын байгууллагаас тодруулахыг би (бид) зөвшөөрч байна.

Иргэн бол:

Өөрийн биеэр

Итгэмжлэгдсэн төлөөлөгч

Гарын үсэг	Овог нэр
Огноо	Албан тушаал

Хуулийн этгээд бол хуулийн этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Удирдах ажилтан

Холбогдох ажилтан

Гарын үсэг	Овог нэр
------------	----------

Огноо	Албан тушаал
-------	--------------

2. Хүсэлт гаргагчийн ерөнхий мэдээлэл

Өргөдөл гаргагчийн нэр

Улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг крилл үсгээр бичнэ.

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

Өргөдөл гаргагч нь иргэн бол

Иргэний үнэмлэхийн хуулбар

Ажлын байрны хаяг

Аймаг/хот	Зип код
Дүүрэг/ Баг, хороо	Утас:
Гудамж, байр хаалганы дугаар	Имэйл:

Шуудан хүлээн авах хаяг /Үйл ажиллагаа явуулах хаягтай ижил бол бөглөхгүй/

Шуудангийн хаяг	
-----------------	--

Холбоо барих хүний мэдээлэл

Албан тушаал	Овог, Нэр	Утас	Факс	И-Мэйл

3. Тоног төхөөрөмжийн мэдээлэл

3.1	Тоног төхөөрөмжийн нэр	
3.2	Загвар	
3.3	Үйлдвэрлэгчийн нэр	
3.4	Харилцах хүний нэр	
3.5	Утас	
3.6	И-мэйл	
3.7	Төрөл (гар утас г.м)	
3.8	Дэмжиж ажиллах технологи GSM/LTE/BT г.м)	
3.9	Үйлдвэрлэсэн улс	
3.10	Үйлдвэрлэгчийн хаяг	
3.11	Тоног төхөөрөмжийн товч танилцуулга	
3.12	Програм хангамжийн хувилбар	
3.13	Техник хангамжийн хувилбар	

3.14	Санал	
------	-------	--

4. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт		
№	Үзүүлэлт	Хэмжээ
4.1	Хэрэглээ зориулалт	
4.2	Ажиллах давтамжийн зурвас (МГц)	
4.3	Гаралтын чадал (мВт)	
4.4	Модуляцын төрөл (AM, FM, OFDM г.м)	
4.5	Сувгийн зай	
4.6	Антенны өсгөлт (мВт)	
4.7	Антенны төрөл	
4.8	Холбох кабелийн төрөл	

5. Мөрдөх стандартууд				
№	Стандартын төрөл	Мөрдөх стандарт	Сорилтын дүнгийн огноо	Сорилтын дүнгийн дугаар
5.1	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа			
5.2	Цахилгаан соронзон зохицоо			
5.3	Радио спектр			
5.4	Бусад			

6. Бүрдүүлэх баримт бичиг		
6.1	Албан бичиг	
6.2	Үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн тохирлын мэдэгдэл	
6.3	Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгүүд	
6.3.1	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	
6.3.2	Цахилгаан соронзон зохицоо	
6.3.3	Радио спектр	
6.4	Ашиглалтын танилцуулга, тохиргоо хийх заавар	
6.5	Зураг: гадаад, дотоод	
6.6	Хэрэглэгчийн гарын авлага: Англи эсвэл Монгол хэл дээр	
6.7	Техникийн үзүүлэлт	
6.8	Шаардлагатай тохиолдолд өргөдөл гаргагчаас нэмэлт мэдээлэл, бүтээгдэхүүний дээж гаргуулна	

----- оОо -----

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
4 дүгээр хавсралт

Өргөдөл гаргах албан хүсэлтийн загвар

[Хүсэлт гаргагч байгууллагын албан бланк]

Харилцаа холбооны зохицуулах хороонд

Тохирлын гэрчилгээ хүсэх тухай

..... /байгууллагын нэр/..... нь онд байгуулагдсан бөгөөд
..... чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

[нэмэлт мэдээллийг дурьдаж болно]

Манай байгууллага улсаас импортлосон /төрөл, ангилал/..... тоног
төхөөрөмжийг баталгаажуулах хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу тохирлын гэрчилгээ
олгоно уу.

[нэмэлт мэдээллийг дурьдаж болно]

Хүсэлтэд маягт болон хавсралт материал нийт ... хуудас хавсаргасан болно.

Захиралгарын үсэг.... /.....нэр...../
Тамга

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
5 дугаар хавсралт

[Өргөдөл гаргагч нь хувь хүн бол энэ загварыг ашиглана.]

Харилцаа холбооны зохицуулах хороонд

Тохирлын гэрчилгээ хүсэх тухай

*Иргэновогтой би /регистрийн дугаар/улсаас импортлосон
...../төрөл, ангилал/..... тоног төхөөрөмжийг баталгаажуулах хүсэлтэй байгаа тул зохих
журмын дагуу тохирлын гэрчилгээ олгоно уу.*

[нэмэлт мэдээллийг дурьдаж болно]

Өргөдөлд маягт болон хавсралт материал нийт ... хуудас хавсаргасан болно.

.....гарын үсэг.... /.....нэр...../ Регистрийн дугаар

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
6 дугаар хавсралт

Нийлүүлэгчийн мэдэгдлийн загвар
[Үйлдвэрлэгч/Нийлүүлэгчийн албан бланк]

Харилцаа холбооны зохицуулах хороонд
Нийлүүлэгчийн мэдэгдэл

Би/Бид.....
(үйлдвэрлэгч/нийлүүлэгчийн нэр)

.....
.....
.....

(хаяг)

бүтээгдэхүүнд зөвхөн би/бид хариуцлага хүлээнэ

.....
.....

(бүтээгдэхүүний нэр, төрөл эсхүл загвар болон дугаар зэрэг нэмэлт мэдээлэл)

зохицуулалт, стандарт хангасан дараах техникийн үзүүлэлттэй болохыг мэдэгдэж байна.

.....
.....

..... дараах гэрчилгээ/сорилтын дүнд үндэслэн техникийн үзүүлэлтийг
шалгаж мэдэгдэл гаргасан

..... холбогдох баримт бичгийг зохицуулах
хороонд илгээсэн.

Гарын үсэг..... Огноо:

(үйлдвэрлэгч/нийлүүлэгчийг төлөөлж)

Нэр, Албан тушаал

(овог нэр, гарын үсэг зурсан ажил үүрэг)

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
7 дугаар хавсралт

*ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООГ ТӨЛӨӨЛЖ*
*/Тамга/
ДАРГА*

*АЖ, АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ*
*/Тамга/
ЗАХИРАЛ*

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭХ ГЭРЭЭ

20....онысарын.....ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1 “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 14.3, 15.6.1 “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.3.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн энэхүү гэрээг аж ахуйн нэгж, байгууллагатай тухайн гэрчилгээ эзэмших хүчинтэй хугацааны турш байгуулж, биелэлтийг ханган ажиллана. Энэхүү гэрээг нэг талаас: Харилцаа холбооны зохицуулах хороо / цаашид “Гүйцэтгэгч” гэх/-ны дарга, нөгөө талаас гэрчилгээ эзэмшигч байгууллага /цаашид “захиалагч” гэх/ тохирлын гэрчилгээг хэрэглэх талаар дараах зүйлийг харилцан тохиролцов.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг

2.1 Гэрчилгээнд заасан бүтээгдэхүүний стандарт, техникийн үзүүлэлтэд өөрчлөлт орсон, хүчингүй болсон тухай бүрд захиалагчид бичгээр мэдэгдэж, гэрээний хугацааны асуудлыг шийдвэрлэнэ.

2.2 Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээг хугацаанаас өмнө цуцалж, хэвлэл, мэдээллээр нийтэд мэдээлнэ.

2.3 Гүйцэтгэгч гэрчилгээнд заасан бүтээгдэхүүн нь стандартын үзүүлэлт, шаардлагад тохирч байгаад зохих журмын дагуу магадлан хяналт тавина.

2.4 Гүйцэтгэгч нь тохирлын гэрчилгээ хэрэглэх бүтээгдэхүүн /тоног төхөөрөмж/-ийн нэр төрөл, захиалагчийн хаягаас бусад мэдээллийг бусад аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд захиалагчийн албан ёсны зөвшөөрлөөр өгч, нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Гурав. Захиалагчийн эрх, хүлээх үүрэг

3.1 Тохирлын гэрчилгээнд заасан стандартын үзүүлэлт, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн /тоног төхөөрөмж/-ийг импортлож, үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлнэ.

3.2 Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө гэрээний хугацааг сунгуулах хүсэлтээ гаргана.

3.3 Бүтээгдэхүүн нь тохирлын гэрчилгээнд заасан стандартын үзүүлэлт, шаардлагад тохироогүйгээс хэрэглэгчид учирсан хохирлыг захиалагч хариуцана. (холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.)

3.4 Захиалагч нь тохирлын тогтвортой байдлын магадлан хяналтыг гэрээний хугацаанд хоёр жилд нэг удаа явуулах эрхийг нийлүүлэгчид олгоно.

3.5 Захиалагч нь тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлийн технологид орсон өөрчлөлтийг өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор Гүйцэтгэгчид албан ёсоор мэдэгдэж асуудлыг шийдвэрлүүлнэ.

3.6 Бүтээгдэхүүн нь стандарт, норматив баримт бичгийн шаардлагыг хангахгүй байгаа тухай хэрэглэгчийн гомдлыг захиалагч хариуцна.

3.7 Захиалагч нь гэрчилгээнд дурдсан бүтээгдэхүүний талаар хэрэглэгчээс гаргасан санал, гомдол, тэдгээрийг барагдуулсан талаар бүртгэл хөтөлж, тухай бүр гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

3.8 Захиалагч нь энэ гэрээний хүрээнд бүтээгдэхүүнээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбогдох хуульд нийцүүлэн сурталчлах эрхтэй.

3.9 Захиалагч нь баталгаажуулалтын байгууллагын нэр хүндийг унагаах байдлаар бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хэрэглэхгүй.

3.10 Захиалагч нь баталгаажуулалтыг түдгэлзүүлэх цуцлах буюу зогсоох үед баталгаажуулалтыг аливаа байдлаар иш татсан агуулгатай сурталчилгааг хэрэглэхгүй .

3.11 Захиалагч нь мэдээллийн хэрэгсэлд бүтээгдэхүүний сурталчилгааг хийхдээ баталгаажуулалтын байгууллагын шаардлагыг хангасан байна.

3.12 Гүйцэтгэгчийн “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид тохирлын тэмдэг олгох журам”, “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид тохирлын тэмдэг хэрэглэх заавар”- т зааснаар баталгаажсан тоног төхөөрөмжийн серийн дугааруудыг зохицуулах хороонд ирүүлж зөвшөөрөл авах , тоног төхөөрөмжийн сери тус бүр дээр тохирлын тэмдэг тавьж зах зээлд нийлүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1 Захиалагч нь бүтээгдэхүүний тохирлын тогтвортой байдлын хяналт, сорилт туршилт, зохион байгуулалтын холбогдолтой бүх зардлыг хариуцна. Тохирлын гэрчилгээ хэрэглэсний төлбөр төгрөгийг Харилцаа холбооны зохицуулах хорооны банкин дах тоот гүйцэтгэгчийн дансанд оруулна.

4.2 Энэхүү гэрээ байгуулсан өдрөөс (аль нь болохыг зур)

1 жилийн 2 жилийн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

4.3 Хэрэв гэрээний хугацааг сунгах, гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай талууд нэмэлт тодотгол хавсаргаж, түүнийг харилцан тохиролцон баталж тамга, тэмдэг дарсан тохиолдолд хүчинтэйд тооцно.

4.4 Тодорхой нэг бүтээгдэхүүнд гэрчилгээ хэрэглэхийг зогсоосон тэр хугацаанаас эхлэн гэрээ нь хүчингүй болно.

4.5.1 Гүйцэтгэгчээс бүтээгдэхүүн нь аюултай гэж тогтоосон	Хугацаа заахгүй
4.5.2 Техникийн үзүүлэлтийг зөрчсөн	60 хүртэл
4.5.3 Гүйцэтгэгчид төлбөрөө төлөөгүй	60 хүртэл
4.5.4 Энэхүү гэрээний бусад заалт зөрчигдсөн	60 хүртэл

Гүйцэтгэгчийг төлөөлж:

РДЗХГазрын дарга

.....

Захиалагчийг төлөөлж:

.....

/Тамга/

----- оОо -----

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
8 дугаар хавсралт

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ
Гэрчилгээний дугаар: ID: RYUXXXXXX

Хүсэлт гаргагч:

Үйлдвэрлэгч:

Харилцаа холбооны зохицуулах хороо нь дараах бүтээгдэхүүнийг холбогдох стандарт,
техникийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа тул гэрчилгээг олгов.

Бүтээгдэхүүний нэр:

Загвар :

Брэнд (заавал биш):

Ажиллах давтамжийн зурвас:

Үйлдвэрлэсэн улс:

Технологи:

Мөрдөх стандарт:

Гэрчилгээг олгоход үндэслэсэн баримт бичгүүд:

1. Сорилт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн нэр
2. Сорилтын дүнгийн дугаар, огноо

3. Баталгаажуулалтын үнэлгээний хорооны хурлын шийдвэрийн дугаар, огноо . .
.

Олгосон огноо:

Дуусах огноо:

ДАРГА

Монгол Улс
Улаанбаатар хот 14201
Сүхбаатар дүүрэг
Сүхбаатарын гудамж-13
Метро бизнэс төв, А блок
5 давхар

Утас: 304257
Факс: 327720
И-мэйл: info@crc.gov.mn
Вэб: www.crc.gov.mn

CERTIFICATE OF CONFORMITY

Certificate Number: ID: RYYXXXXXX

Applicant

Name:

Address:

Manufacturer

Name:

Address:

The Communications Regulatory Commission of Mongolia hereby certifies that following products(s) confirm(s) to related technical specifications and standards.

Product Name:

Brand (if applicable):

Model:

Operating Frequency Range:

Country of Origin:

Technology:

Compliance Standards:

This certificate is granted with terms of reference defined below:

- 1. **Name of accredited laboratory.**
- 2. **Date and number of test report.**

Standards	Issued Day/Month/Year	Report number
Health and Safety		
EMC		
RF		
Other		

- 3. **Date and number of decisions made by meeting of conformity council**
.

DATE of ISSUE:

DATE of EXPIRY:

Chairman and CEO

COMMUNICATIONS REGULATORY
COMMISSION OF MONGOLIA
Metro Business Center, A block
5th floor, Sukhbaatar Street -13
Sukhbaatar district
Ulaanbaatar 14201, MONGOLIA

Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам"-ын
9 дүгээр хавсралт

Харилцаа холбооны зохицуулах хорооны баталгаажуулалтын үйл
явцад оролцох ажилтны амлалтын гэрээ

20...оны ... сарынөдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээг нэг талаас Баталгаажуулалтын байгууллагыг төлөөлж РДЗХГ-ын дарга.....овогтой....., нөгөө талаас.....
.....(байгууллагын нэр).....(албан тушаал)-тай
.....овогтой нар Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.3 дугаар заалт, ЗОХИЦУУЛАХ ХОРОО-ны “Хөдөлмөрийн дотоод журам”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Баталгаажуулалтын мэргэшсэн шинжээчийн дүрэм”, MNS ISO/IEC 17065:2013 “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага” олон улсын стандартын 6.1.3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон байгуулав.

Хоёр. Ажилтны баталгаажуулалтын үйл
явцад оролцох амлалт

1.1 Баталгаажуулалтын үйл явцад оролцохдоо “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг баримтлан ажиллана.

1.2 Баталгаажуулалтын үйл ажиллагааны явцад олж авсан аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн болон технологийн мэдээллийн нууцлаг байдлыг хадгалж, “Баталгаажуулалтын явцад олж авсан мэдээллийн нууцлаг байдлыг хадгалах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллана.

1.3 Аж ахуйн нэгж байгуулагатай худалдааны болон бусад сонирхолоос хараат бус байх зарчмыг баримтлан ажиллана.

1.4 Хэрэв хүсэлт гаргагчтай дараах байдлаар харилцаатай буюу ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ талаараа удирдлагадаа урьдчилан мэдэгдэж, үнэлгээний ажилд оролцохоос сайн дураараа татгалзана. Үүнд:

1.4.1 бүтээгдэхүүний нийлүүлэгч буюу зохион бүтээгч;

1.4.2 үйлчилгээ үзүүлэгч буюу боловсруулагч;

1.4.3 үйл явцын ажиллуулагч буюу боловсруулагч.

Гурав. Гэрээний давтан баталгаажуулалт

3.1 Энэхүү гэрээг анх удаа байгуулснаас хойш баталгаажуулалтын үйл явцад оролцох бүрдээ байгуулах ба баталгааны хуудас \хавсралт\ - д тухай бүр гарын үсэг зурснаар батлагдсанд тооцно.

Гэрээ байгуулсан

РДЗХГ-ын дарга Ажилтан

Маягт 1

Амлалтын гэрээний баталгаа

№	Ажилтны нэр	Хүсэлт гаргагч	Огноо	Гарын үсэг

oOo

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
10 дугаар хавсралт

Маягт 2

Баталгаажуулж тохирлын гэрчилгээ олгосон тоног төхөөрөмжийн бүртгэл

Д/д	Тохирлын гэрчилгээн ий дугаар	Үйлдвэр-лэгчийн нэр	Тоног төхөөрөм-жийн нэр /	Брэнд нэр/ Загвар	Тохирлын гэрчилгээ эзэмшигч	Гэрчилгээ олгосон өдөр	Гэрчилгээ дуусах хугацаа

Бүртгэл хөглөсөн:

“Мэдээлэл, харилцаа холбооны тоног тохооромжийн
загварыг баталгаажуулах журам”-ын
11 дүгээр хавсралт

РАДИО БА ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗААВАЛ БАТАЛГААЖУУЛАЛТАД
ХАМРАГДАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ, МӨРДӨХ СТАНДАРТУУД
/Communication equipment subject to mandatory type approval/

Технологи <i>/Technologies/</i>	Төхөөрөмж <i>/Equipment/</i>	Стандарт <i>/Applicable Standards/</i>
Нийтийн ходолгөөнт <i>/Public Mobile/</i>	GSM гар утас, терминалууд <i>/GSM Handsets, terminals & ancillary equipment/</i>	EN 301 489-7 EN 301 511 EN 301 609-4
	GSM бааз станцууд болон туслах радио төхөөрөмжүүд <i>/GSM Base Station and ancillary equipment/</i>	EN 301 489-8 EN 301 502 EN 301 609-4 MNS 6605:2016
	GSM гар утас, терминалууд <i>/CDMA Handsets, terminals & ancillary equipment/</i>	EN 301 489-23 EN 301 489-25
	CDMA бааз станцууд болон туслах радио төхөөрөмжүүд <i>/CDMA Base Station and ancillary equipment/</i>	EN 301 489-26 MNS 6605:2016 MNS 5697:2006 MNS 5739:2007
	Утасгүй харилцууртай телефон аппарат <i>/DECT cordless telecoms equipment/</i>	EN 301 489-6 EN301 406
	UMTS гар утас болон терминалууд болон UMTS бааз станцууд болон туслах радио төхөөрөмжүүд <i>/UMTS handsets and related equipment UMTS base stations/</i>	EN 301 908-2 EN 301 908-6 EN 301 489-24 EN 301 908-3 EN 301 908-7 EN 301 908-11 EN 301 489-23 MNS 6605:2016
	LTE гар утас болон терминалууд <i>/LTE Handsets, terminals & ancillary equipment/</i>	EN 301 908-1, 3,11, 14, 15, 18 ITU-R M.1457-9 EN 301 908-13 CRC-2018-23
	LTE бааз станцууд болон туслах радио төхөөрөмжүүд <i>/LTE Base Station and ancillary equipment/</i>	EN 301 489-50 EN 301 908 MNS 6611:2016 CRC-2018-23 MNS 6605:2016
Хувийн хэрэгцээний радио тохөөрөмж	Сонирхогчийн радио холбооны төхөөрөмж <i>/Amateur radio and ancillary equipment/</i>	EN 301 489-15 EN 301 783-2 CRC-2019-09

<i>/Private Mobile/</i>	ТЕТРА радио төхөөрөмж <i>/TETRA radio equipment/</i>	EN 301 489-18 EN 303 035-1 EN 303 035-2 CRC-2019-09
	Богино долгионы радио станц болон туслах төхөөрөмж <i>/Short wave radio station and ancillary equipment/</i>	EN 300 135 EN 300 135-1 EN 300 135-2
	Аналог болон тоон системд ажилладаг харилцааны радио холбооны станц <i>/Analogue and digital PMR equipment/</i>	EN 301 489-5 EN 300 793 EN 300 471-2 EN 300 086-2 EN 300 113-2 CRC-2019-09
	Богино зайн радио холбооны төхөөрөмж болон туслах төхөөрөмж <i>/Short range PMR and ancillary equipment/</i>	EN 300 390-2 EN 301 166-2 CRC-2019-09
	Байршил тогтоох болон радио илрүүлэгч төхөөрөмж <i>/Radar for radionavigation/</i>	EN 302 248 EN 302 194
	Далайн холбоо <i>/Maritime Radio/</i>	EN 300 698 EN 301 025 EN 301 178
	Суурин утасгүй төхөөрөмж <i>/Fixed Mobile/</i>	RLAN, Wi-Fi, WLAN
WiMAX төхөөрөмж <i>/WiMAX equipment/</i>		EN 301 753
Суурин утасгүй төхөөрөмж болон туслах төхөөрөмж <i>/Fixed Wireless Access and ancillary equipment/</i>		EN 301 489-4 EN 302 217-2-2 EN 302 217-3 MNS 5741:2007 MNS 6527:2015 CRC-2018-23
Цэгээс цэгт холболт хийх зориулалттай радио линк <i>/Digital Microwave Radio/</i>		EN 301 489-4 EN 302 217-2-2 EN 302 217-3 EN 302 217-4-2 MNS 5467:2005 CRC-2018-32
Богино зайн радио холбооны төхөөрөмж <i>/Short Range/</i>	ISM	EN 300 220 EN 300 330 EN 300 440 MNS 6545:2015 CRC-2019-14
	ISM, WLAN , Bluetooth	EN 300 440 EN 300 328 MNS 6545:2015 CRC-2019-14
	Богино зайн радар болон радио илрүүлэгч <i>/SRD radar systems, Radio determination Application/</i>	EN 300 440 EN 302 288 EN 302 372 MNS 6545:2015 CRC-2019-14

	Автомашин болон зам тээврийн хяналтын хяналтын төхөөрөмж <i>/Vehicle telematics, Road transport and traffic telematics/</i>	EN 300 674 EN 200 674 EN 301 091 MNS 6545:2015 CRC-2019-14
	Автомашин удирдлага, дохиолол болон гар утастай холбогдох систем <i>/Car immobilizers, alarm systems, data transfer to handheld devices etc./</i>	EN 302 291 EN 300 330 EN 300 220 MNS 6545:2015 CRC-2019-14
	Загварын хяналтын төхөөрөмж <i>/Purpose of controlling movement of a model/</i>	EN 300 220 MNS 6545:2015 CRC-2019-14
	Эрүүл мэндийг хянах төхөөрөмжид ашиглаж байгаа утасгүй төхөөрөмж <i>/Active Medical Implant, hearing aids etc. Wireless applications in healthcare & listening devices/</i>	EN 301 839 EN 302 537 EN 302 195 EN 302 510 EN 300 422 MNS 6545:2015 CRC-2019-14
	Утасгүй чанга яригч, утасгүй чихэвч гэх мэт <i>/Cordless loudspeakers, headphones etc./</i>	EN 301 357 MNS 6545:2015 CRC-2019-14
	Автомашин удирдлага, хулгайн эсрэг систем, байршил тогтоох систем гэх мэт автомашинд суурилагдсан радио төхөөрөмж <i>/Vehicle Immobilizer, antitheft system, navigation device etc. Vehicle fitted radio products/</i>	EN 300 220 EN 300 328 EN 300 440 EN 301 091 EN 302 291 EN 300 330 MNS 6545:2015 CRC-2019-14
	Радио давтамжаар таних систем <i>/Article identification, asset tracking, alarms etc. Radio Frequency identification applications/</i>	EN 302 291 EN 300 440 MNS 6545:2015 CRC-2019-14
	Гэрийн радио төхөөрөмжүүд <i>/Home radio electronic devices/</i>	EN 300 220 EN 300 440 MNS 1898:1989 MNS 6545:2015 CRC-2019-14
Хиймэл дагуулын төхөөрөмж <i>/Satellite/</i>	1 ГГц-ээс доош радио давтамжийн зурваст ажилладаг сонирхогчийн хиймэл дагуулын холбоо <i>/Amateur Satellite Radio MSS equipment operating below 1 GHz/</i>	EN 301 721
	1-3 ГГц радио давтамжийн зурваст ажилладаг хиймэл дагуулын хэрэглэгчийн төхөөрөмж (GPS, S-DAB)	EN 301 425 EN 301 441 EN 301 442 EN 301 444 EN 301 681

	<i>/Radar & Navigation Systems and Active Sensors (GPS) S-DAB, MSS equipment operating between 1-3GHz/</i>	
	VSAT-ын төхөөрөмжүүд, хиймэл дагуулын телевиз болон туслах радио төхөөрөмж <i>/Satellite TV other VSAT and ancillary equipment/</i>	EN 301 428 EN 301 443 EN 301 360 EN 301 459 MNS 5469:2005 MNS 6404:2013
Өргөн нэвтрүүлгийн төхөөрөмж <i>/Broadcasting/</i>	Радио өргөн нэвтрүүлгийн нэвтрүүлэх болон хүлээн авах радио төхөөрөмж <i>/Sound broadcasting equipment/</i>	EN 301 489-11 EN 302 018-2 CRC-2018-24 MNS 4909:2000 MNS 5477:2005 MNS 5476:2005
	Телевизийн өргөн нэвтрүүлгийн нэвтрүүлэх болон хүлээн авах радио төхөөрөмж <i>/Vision broadcasting equipment/</i>	EN 301 489-7 EN 301 489-1 EN 302 297 CRC-2018-17 MNS 4910:2000 MNS 5208:2002 MNS 5397:2004 MNS 6400:2013
PSTN	Нийтийн сүлжээнд холбогддог аналог төхөөрөмж Телефон аппарат Факсын аппарат Аналог модем Автомат хариулагч <i>Analog PSTN TTE:</i> •Single Line equipment directly connecting to analog PSTN •Single Line telephony •Fax Machines •Analogue Modems •Answering machines •Adjuncts and telephones offering analogue CLI •Subscriber Meter •PSTN Connected Security Alarms	ETSI TBR 021 ETSI ES 201 187 ETSI TBR 038 ETSI ES 201 235-3 ETSI ES 201 912 ETSI TS 103 912 ETSI EN 300 659-2 ETSI ES 200 778-2
xDSL	HDSL SHDSL SDSL ADSL	ETSI ETR 152 ETSI TS 101 135 ITU G992.1 ETSI TS 101 524 ETSI ES 202 913 ETSI TS 101 952-1-1 ETSI TS 101 952-1-2
Бусад дууны төхөөрөмж	Таксфоны аппарат <ul style="list-style-type: none">• Payphone• PBX and Key Systems	ETSI I-ETS 300 400 ETSI ES 201 168 ITU-T Rec. G.711 ITU-T Rec. H.323 IETF MEGACO IP Phone

/Other Voice Equipment/	<ul style="list-style-type: none"> Voice over IP terminals 	Media Gateway standard IETF Session Initiation Protocol (RFC3261, RFC3262, RFC3263, RFC3264, and RFC3265). IETF RFC1933 ETSI ES 201 168
Өгөгдөл дамжуулах үйлчилгээ /Switched Data services/	Basic Rate ISDN Primary Rate ISDN X25, X21 Frame Relay	ETSI TBR 003 ETSI TBR 008 ITU- T Recommendation G.961 ETSI ETR 080 ETSI TBR 004/A1 ETSI TBR 008 ETSI TBR 2 ITU-T recommendation X.25, ITU-T Recommendation X.21, ETSI TCRTR 020 , ETSI ETS 300 399-1 ETSI ETS 300 399-2 ETSI ETS 300 399-3

Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагууд

Төрөл /Type/	Applicable Standard /Холбогдох стандартууд/	Description /Тодорхойлолт/
Цахилгаан /Electrical/	EN 60950 or IEC 60950	Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн цахилгаан аюулгүй байдал <i>/Electrical Safety of information technology equipment/</i>
Утасгүй холбоо /Radio/	EN 50360	Гар утасны цахилгаан соронзон орны хүний биед нөлөөлөх хязгаарын стандарт (300 МГц-3Гц) <i>/Product standard to demonstrate the compliance of mobile phones with the basic restrictions related to human exposure to electromagnetic fields (300 MHz – 3 GHz)/</i>
	EN 50364	0-10 ГГц-ийн радио давтамжийн зурваст ажилладаг төхөөрөмжүүдээс хүний биед үзүүлэх цахилгаан соронзон орны нөлөөллийн хязгаар <i>/Limitation of human exposure to electromagnetic fields from devices operating in the frequency range 0 Hz to 10GHz, used in Electronic Article Surveillance (EAS), Radio Frequency/Identification (RFID) and similar applications</i>
	EN 50371	10МГц-300ГГц радио давтамжийн зурваст ажилладаг бага чадлын цахилгаан төхөөрөмжүүдийн ялгаруулах цахилгаан соронзон орны хүний биед үзүүлэх нөлөөний нийцлийг харуулах ерөнхий стандарт

		<i>/Generic standard to demonstrate the compliance of low power electronic and electrical apparatus with the basic restrictions related to human exposure to electromagnetic fields (10 MHz – 300 GHz) – General public/</i>
	EN 50385	Баз станцууд болон утасгүй суурин станцуудын цахилгаан соронзон орны хүний биед үзүүлэх нөлөөллийн нийцлийн стандарт (10МГц-300ГГц) <i>/Product standard to demonstrate the compliance of radio base stations and fixed terminal stations for wireless with the basic restrictions related to human exposure to electromagnetic fields (10 MHz – 300 GHz)/</i>
	EN 60215	Радио нэвтрүүлэгч төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага <i>/Safety requirements for radio transmitting equipment/</i>
	EN 50392	0-300ГГц радио давтамжийн зурваст ажилладаг электрон цахилгаан төхөөрөмжүүдийн ялгаруулах цахилгаан соронзон орны хүний биед үзүүлэх нөлөөний нийцлийг харуулах ерөнхий стандарт. <i>Generic standard to demonstrate the compliance of electronic and electrical apparatus with the basic restrictions related to human exposure to electromagnetic fields (0 Hz– 300 GHz)</i>
Шилэн кабель ба лазер <i>/Optical and Laser/</i>	EN 60825-1 or IEC 60825-1	Лазер төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагаа- 1-р хэсэг, Төхөөрөмжүүдийн ангилал, нөхцөл шаардлага ба гарын авлага <i>Safety of laser products - Part 1: Equipment classification, requirements and user's guide</i>
	EN 60825-2 or IEC 60825-2	Лазер төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагаа- 1-р хэсэг, Оптик кабелийн төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа <i>Safety of laser products - Part 2: Safety of optical fiber communication systems</i>

----- oOo -----